



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 134

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,347,250 /хоёр сая гурван зуун дөчин долоон мянга хоёр зуун тавь/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Дэд станц (цахилгаан хангамжийн барилга байгууламж)-ыг хавсралтын дагуу мэргэжлийн байгууллага болох “Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХКомпанийн харьяа “Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбар”-ын өмчид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ц.Ганзориг) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Цахилгаан хангамжийн барилга байгууламжийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохих хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ



2

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын
23-ний өдрийн 23 тогтоолын хавсралт

ГБХЗХГазрын балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Дэд станц	2012.12.01	1	2,347,250	516,177.75	1,831,072.25
Хөрөнгийн дүн				2,347,250 /хоёр сая гурван зуун дөчин долоон мянга хоёр зуун тавь/	516,177.75 /таван зуун арван зургаан мянга нэг зуун далан долоон төгрөг далан таван мөнгө/	1,831,072.25 /нэг сая найман зуун гучин нэгэн мянга далан хоёр төгрөг хорин таван мөнгө/